



# СОЁМБО МЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№199 /409/

2022.11.04

Цаг үе, үйл явдал

## ДЭЛХИЙН АВАРГЫН ХОС АЛТАН МЕДАЛЬТАН ЭХ ОРОНДОО ИРЛЭЭ



Бүгд Найрамдах Энэтхэг Улсад зохион байгуулагдсан Туухай өргөлтийн ДАШТ-ий 68 килограммын жингийн түлхэлттэй болон огцом өргөлтийн төрөлд Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагч, дэд ахлагч Э.Буджав хос алтан медаль хүртсэн бөгөөд тэрээр өнөөдөр эх орондоо ирлээ.

Түүнийг БХЯ, ҮБХИС, "Алдар" спорт хорооны төлөөлөл, ҮЖҮНХ-ийн бие бүрэлдэхүүн Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудалд "Ялалт" маршийг эгшиглүүлэн хүндэтгэлтэйгээр угтан авлаа. Мөн түүний гэр бүл, анд нөхөд, нутгийн зөвлөлийн хамт олон баярт мөчийг нь хуваалцахаар хүрэлцэн очсон байв.

Тэрээр "Эх орондоо буухад ингэж угтаж авна гэж төсөөлөөгүй. Үнэхээр сайхан мэдрэмж байна. Энэхүү амжилтаа цааш улам ахиулахын зэрэгцээ Зэвсэгт хүчнээс олон залуусыг бэлтгэн дэлхийн аварга төрүүлэхийг хүсэж байна. Миний хувьд тэмцээнд мордохдоо чамлахааргүй амжилт үзүүлээд ирнэ гэсэн итгэлээр дүүрэн явсан. Энд нэг зүйлийг онцлоход, Солонгос Улсад очоод дараагийн нислэгээ хүлээж байхдаа Монгол Улсын иргэн Батсүх гэдэг ахтай танилцсан, энэ ах маань тэмцээний үеэр ард минь асаалттай танк мэт намайг зоригжуулж байсан. Яагаад ч юм бэ, бурхан надад тусламж илгээсэн юм шиг санагдсан. Намайг дэмжиж байсан бүх хүмүүстээ баярлалаа. Бүхий л цаг үед найдвартай ар тал, тулах цэг, бууж өгөхгүй байх шалтгаан болж байсан Монгол Улсын Зэвсэгт хүчний удирдлага, бие бүрэлдэхүүнд талархал илэрхийлье. Итгэлийг зүтгэлээр хариулах болно. Монгол Улсын төлөө зүтгэе" хэмээв.

Дэлхийн 18 орны 250 гаруй тамирчин оролцсон тус наадмаас спортын дэд мастер, дэд ахлагч Э.Буджав ийнхүү хос алтан медаль хүртсэнээр Монгол Улсын спортын түүхэнд шинэ амжилтыг тогтоож байгаа юм.

Х.УНДАРМАА

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 1	☁️ -12

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 36	☁️ 23

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,416	3,423
EUR 🇪🇺	3,410	3,430
CNY 🇨🇳	467	469
RUB 🇷🇺	52.30	52.60
JPY 🇯🇵	23.12	23.40
KRW 🇰🇷	2.41	2.43

### ЗУРХАЙ



2022.11.04 /БААСАН ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 11

**НАМРЫН АДАГ ЦАГААН НОХОЙ САР**  
**НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ТАХИА ӨДӨР**

Үс засуулбал:

Эрхтэн хурц болно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

07.40-17.32

Барилдлага:

Түлэх

Шүтэн барилдлага:

Сэрэхүй

Тухайн өдөр хонь, бич, тахиа, могой, морь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр шатаахын учралтай тул зовлонтой, цэрэг татах дайсанаа дарах хатуу үйлийг үүсгэвээс зохистой, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.

## “БАХАРХАН ДУРСАХ ОН ЖИЛУУД” СЭДЭВТ ҮЗЭСГЭЛЭН МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙД...



Өнөөдөр Монгол цэргийн музейд Цэргийн доторх улс төрийн байгууллагын 100 жил, дотооддоо мэргэжлийн улс төрийн ажилтан бэлтгэж эхэлсний 50 жилийн ойд зориулсан “Бахархан дурсах он жилүүд” үзэсгэлэнгийн нээлтийн арга хэмжээ боллоо. Эл арга хэмжээнд Монгол Цэргийн музейн захирал хурандаа Д.Ганзориг, ЗХЖШ-ын Сургалт, бэлтгэлийн газрын Суртал хүмүүжил, сэтгэл зүйн хангалтын хэлтсийн дарга хурандаа Т.Мөнхсаруул, “Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны нэгдсэн эвлэл” ТББ-ын тэргүүн бэлтгэл хурандаа Б.Жуваа,

гүйцэтгэх захирал бэлтгэл дэд хурандаа Н.Энхболд, үе үеийн улс төрийн ажилтнууд оролцсон юм.

“Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны нэгдсэн эвлэл” ТББ-ын тэргүүн бэлтгэл хурандаа Б.Жуваа үзэсгэлэнгийн нээлтийн арга хэмжээнд хүрэлцэн ирсэн ахмад дайчид, хүндэт зочдодоо баярлаж талархсанаа илэрхийлэхийн зэрэгцээ музейд шинээр тохижуулан байгуулж буй “Цэргийн улс төр, соёл хүмүүжлийн ажилтны булан”-г үзмэрээр баяжуулж, бусдадаа сурталчлан таниулж яваарай хэмээн бие бүрэлдэхүүнд захилаа.

Тус үзэсгэлэнд үе үеийн улс төрийн ажилтнуудын хэрэглэл, МХЗЭ, ҮБХИС-Нийгэм хүмүүнлэгийн тэнхимд ашиглагдаж байсан эд өлгийн зүйлс дэлгэгдэж, үзэгч олны хүртээл болсон юм.

“Энэ үеэр Цэргийн улс төр, Соёл хүмүүжлийн ажилтны нэгдсэн эвлэл” ТББ нь анхны тугаа мандуулж хүндэтгэлийн байранд залсан онцлог үйл явдал тохиолоо. Мөн Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын хамт олон уран бүтээлийн дээжсээ үзэгч олонд өргөн барив.



### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 636,922,505

Эдгэрсэн

Нийт: 616,326,847

Нас барсан

Нийт: 6,601,924

Цаг үе, үйл явдал

## ЭМЭГТЭЙЧҮҮД ЧУУЛЛАА



### Зэвсэгт хүчний 032 дугаар анги

Ангийн эмэгтэйчүүдийн үзэл бодол, нийгмийн байдал, хувь хүний нэр төр, сүсэг бишрэл, яс үндэс, хөрөнгө чинээ, албан тушаал зэргийг үл харгалзан тэдний нийтлэг эрх ашиг, сонирхлыг хамгаалах, төрөөс эмэгтэйчүүдийн эрхийн талаар баримталж буй бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор долоо хоног бүрийн Пүрэв гарагийг "Эмэгтэйчүүдийн өдөр"

болголоо.

Энэхүү арга хэмжээг ангийн захирагч хурандаа М.Болдбаатар нээж үг хэлсний дараагаар Зөвлөлийн үйл ажиллагааг цаашид хэрхэн өрнүүлэх, ямар ажлуудыг хэрэгжүүлэх талаар эмэгтэйчүүдийн санал, сэтгэгдлийг сонссон юм.

Энэ үеэр соёл хүмүүжлийн албанаас 9 аэтан тодруулж шагнаж урамшууллаа.

## ШИНЭ ДАЙЧДЫН ТӨРСӨН ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭВ



Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний үүргээ биелүүлж 2022 оны хоёрдугаар ээлжээр татагдан алба хааж буй 10, 11 дүгээр сард төрсөн 28 байлдагчийн төрсөн өдрийг дурсамж дүүрэн тэмдэглэн өнгөрүүллээ.

Арга хэмжээг нээж ангийн захирагч хурандаа М.Болдбаатар хэлсэн үгэндээ, "Төрийн торгон цэргийн ангид хугацаат цэргийн алба хаах хугацаандаа төрсөн өдрөө тэмдэглэж, мөр зэрэгцсэн дайчидтайгаа нэгэн өдрийг дурсамж дүүрэн өнгөрүүлж байгаа нь та бүхний амьдралын мартагдахааргүй гэгээн мөч болон

үлдэх учиртай" хэмээн онцоллоо.

Төрсөн өдрөө тэмдэглэж буй шинэ дайчдад Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн дэргэдэх цахилгаан хөгжмийн "Цагаан сүлд" хамтлаг, МУСТА, ахлах ахлагч С.Дашзэвэг, ахлах ахлагч Б.Эрдэнэбаатар, энгийн Б.Мөнхбаясгалан нар ая дууны мэндчилгээ өргөн дэвшүүлэв. Арга хэмжээний төгсгөлд ангийн эмэгтэйчүүд "Задгай цагаан" бүжгийг нийт шинэ дайчдад зааж сургасан юм.

Ахмад Т.ДЭЛГЭРМАА

## БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН "ЭЦЭГ ЭХИЙН ЗӨВЛӨЛ"-ИЙН ЗӨВЛӨГӨӨНД ОРОЛЦЛОО




Баянзүрх дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Баянзүрх дүүргийн Соёлын ордон "Дэлхийн зөн Монгол" олон улсын байгууллагын "Баянзүрх орон нутгийн хөтөлбөр"-ийн хамт олон, Монголын сайн дурынхны төвтэй хамтран төрийн байгууллагын эцэг эхийн зөвлөлийн анхдугаар зөвлөгөөнд Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн гэр бүлийн зөвлөл оролцож арга зүйн зөвлөмж, харилцан туршлага солилцлоо.

Зөвлөгөөнд "Байгууллагын эцэг эхийн зөвлөл ба хүүхэд хамгааллын бодлого" сэдвээр гэр бүл судлаач, доктор Б.Оюун-Эрдэнэ

үндсэн илтгэлийг тавьж, Баянзүрх дүүргийн хүүхэд хамгааллын төлөв байдлын талаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн дарга Ц.Үүрцайх, Хүүхдийн эрхийн зөрчлийг таслан зогсооё аяны талаар Дэлхийн зөн Монгол олон улсын байгууллагыг төлөөлж Э.Золжаргал нар мэдээлэл хүргэж Панел хэлэлцүүлгийг тал бүрийн оролцоотойгоор зохион байгууллаа.

Хэлэлцүүлгээр байгууллагууд хүүхэд хамгааллын чиглэлээр ололт амжилт, сайн туршлагаа хуваалцаж цаашид хэрэгжүүлэх олон ажлын санал санаачилгыг дэвшүүллээ.

Ахмад Л.САРАНЗАЯА



### Уриалга

**ХОШУУЧ ГЕНЕРАЛ  
ЧИМЭДЦЭРЭНГИЙН САМБУУ**

**ЗЭВСЭГ ХҮЧНИЙ 119-Р АНГИ  
ТӨВ АЙМАГ, АЛТАНБУЛАГ СУМ**

### ХОШУУЧ ГЕНЕРАЛ Ч.САМБУУ

Химийн салаа рот, Ангийн захирагч, Химийн цэргийн дарга, Хэлтсийн дарга, Цэргийн ерөнхий дээд сургуулийн захирал, ЗХЖШ-ын орлогч, Тагнуулын газрын дарга, Хан-Уул дүүргийн ахмадын хорооны дарга, Дайнд оролцогсдын Монголын хорооны даргаар ажиллаж Монгол улсын Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэн бэхжүүлэхэд хүчин зүтгэсэн алдар гавьяаг нь алдаршуулан мөнхжүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газрын тогтоол, Батлан хамгаалахын Сайдын тушаалаар Зэвсэгт хүчний 119-р ангийг Хошууч генерал Ч.Самбуугийн нэрэмжит болгон нэрийг нь мөнхжүүлсэн тул 119-р ангийн хүндэтгэлийн Цогцолборт Хошууч генерал Ч.Самбуугийн хөшөөг босгохоор санаачилга гаргаад байна.

### ХАНДИВЫН ДАНС

Хошууч генерал Ч.Самбуугийн Дурсгалыг хүндэтгэх хөшөөг босгоход зориулсан хандивын данс  
ХААН БАНК - 5131309036

### АЖЛЫН ХЭСЭГ

Л. АМАРСАЙХАН 99277999 С. ОЮУНЦЭЦЭГ 95950598  
Ж. БУДЦЭРЭН 80068468 С. ОЮУНЧИМЭГ 99303039  
БҮРНЭЭБААТАР 99135267 ЭРДЭНЭЧУЛУУН 95215899


**ЗЭВСЭГ ХҮЧНИЙ 119-Р АНГИ  
ТӨВ АЙМАГ, АЛТАНБУЛАГ СУМ**

### СУРГАЛТ

## МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №17

### 7 ЭГШГИЙГ УНШИХ, БИЧИХ /үргэлжлэл/

Үндсэн 7 эгшгийн үгийн дунд ордог хэлбэрийг авч үзье. Эхэнд орох хэлбэрүүд цөм титмээр эхэлж байсныг саная. Тэрхүү титэм зурлага тухайн эгшгийн хамгийн тод хэлэгдэж, сонсдох байрыг заадаг. Тэгвэл, үгийн дунд орох гэдэг нь, түүнээс арай сул хэлэгдэх, сонсдох байр нь болно. Хэлэхүйн энэ нарийн зүйлийг монгол бичигт л тусган тэмдэглэж өгснөөрөө онцлог. Титэм зурлага тод хэлэгдэж, сонсдох байрыг заадаг юм бол дунд орох үед тэрхүү зурлагыг нь орхин, эгшгүүдийн үндсэн зурлагыг үлдээхэд болчихно. Дунд орох А, Э, И, О, У, Ө, Ү дармалаар:



Уншигч та дунд ордог А, Э, И, О, У, Ө, Ү гэж аялгуулан уншиж, цэвэр сайхан бичиж сураарай. Тайлбарлах нь: Үгийн дунд орж байна гэдэг нь, нэгэнт үгийн хүйс тодорхой болчихсон байх тул А, Э эгшгийг ялгах шаардлагагүй болж, адилхан шүдээр тэмдэглэж зурлага, цаг хэмнэсэн буйг мэдэж аватгун.



Дарга, ерөнхий редактор, хурандаа  
**САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ**

### ЦАХИМ ХАЯГ

- Батлан хамгаалах яам
- Зэвсэгт хүчний Жанжин штаб

### ЦАХИМ ХУУДАС

- "Соёмбо" сонин
- "Дуулга" студи

- \* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
- \* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
- \* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс: 10018

Цахим шуудан:  
Soymbo@mod.gov.mn  
Утас: 70001029, 3412 (дотуур)